



## ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 227

Улаанбаатар хот

### Г Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шүүх шинжилгээний ерөнхий газрын харьяа Баян-Өлгий аймаг дахь Шүүх шинжилгээний хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 13,845,000.00 (арван гурван сая найман зуун дөчин таван мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө-газар эзэмших эрхийг Гадаадын иргэн, харьяатын газрын Баян-Өлгий аймаг дахь хэлтэст балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрсүгэй.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Мягмар, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Буянбат, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Газар эзэмших эрхийг шилжүүлэн баталгаажуулж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.Нарангэрэл

132000803  
10-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2025 оныг дугаар сарын 07-ны өдрийн  
27. дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ГАДААДЫН  
ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ХЭЛТЭСТ БАЛАНСААС  
БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ БИЕТ БУС ХӨРӨНГӨ-ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон, бүртгэсэн он	Хэм жих нэгж	Тоо хэм жээ	Балансын нийт үнэ (төгрөг)
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх (Баян-Өлгий аймаг, Өлгий, 11 дүгээр баг, Керимбай-1)	2018/2022	m2	923	13,845,000.00
	Нийт дүн				13,845,000.00 (арван гурван сая найман зуун дөчин таван мянга)